

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Энхжаргал

## БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Нийлмэл бордоо худалдан авах

Төслийн дугаар:

ЖС-06/2020

Орхон аймаг  
2020 он

## **Нэг. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Тендер шалгаруулалтын нэр:**Нийлмэл бордоо худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОРАЖСЗДТГ/202001009**

Огноо:**2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр**

**Жаргалант сумын ЗДТГазар нь** сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос  
**Нийлмэл бордоо худалдан авах тухай ЦАХИМ** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү харьцуулалтын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 09.00 минут-аас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаар орж өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаар дамжуулан цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05 дугаар сарын 06-ны 09 цаг 30 минутад Жаргалант сумын ЗДТГ-ын Хурлын зааланд** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ**

**Нутгийн удирдлагын ордон**

**Утас:70397202**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br><br>(а) Үнийн санал;<br>(б) Бараа нийлүүлэх ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(д) Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд заасан баримт бичгийг ирүүлнэ.  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | <b>7.1.</b> Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><br><b>7.2.</b> Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br><br><b>7.3.</b> Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт |

- 8. Гэрээ  
байгуулах  
эрх олгох  
тухай  
мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

<b>ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<p>Сүүлийн [2] жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх Сүүлийн [3 жилийн 2017, 2018,2019 ] туршлагын мэдээлэл /сүүлийн 3 жилийн хугацаанд ижил төрлийн гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/;</p> <p>-Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх-Тодорхойлолт нь тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх шаардлагатай бөгөөд тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна. Ирүүлсэн татварын тодорхойлолтын хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлэхийг анхаарна уу.Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг шалгана. Тендер нээсэн өдрөөр татварын өртэй байвал шууд татгалзана</p> <p>Давуу эрх олгох:</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн үнэлгээнд 10 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан бичгээр мэдэгдэл эх хувиас скайнердаж ирүлнэ.</p> <p>Тендерт оролцогч нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 –д заасныг хангаж байна гэдгийг нотлох баримтыг ирүүлэх шаардлагатай.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) –нд өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр илгээнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p><b>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр</b>  <b>Цаг: 09 цаг 00 минут</b></p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:  <b>ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ.</b></p> <p>Байшин, гудамжны нэр: <b>Жаргалант сум ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>ЗДТГ Санхүү алба 12 тоот</b></p> <p>Аймаг, хот: <b>Орхон аймаг, Жаргалант сум</b></p> <p>Улс: <b>Монгол Улс</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p><b>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдөр</b>  <b>Цаг: 09 цаг 30 минут</b></p>
<b>ТОӨЗ 2.3</b>	<p><b>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</b></p> <p>- Үнийн санал маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.</p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх</li> <li>- Компаний танилцуулга</li> <li>-Захирлын цахим иргэний үнэмлэх эх хувиараа скайнердаж ирүүлэх</li> <li>-Тендерт оролцогчийг төлөөлөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэх эх хувиас ирүүлэх</li> <li>-Мөн тендерт оролцогч нь: Захиалагч байгууллага харьяа татварын байгууллага, эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, захиргааны хэргийн анхан шатны шүүх, шүүхийн шийдвэх гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулан эх хувиар ирүүлэх/аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.</li> <li>-Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдэд нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</li> <li>-Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</li> <li>-Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх</li> <li>-Нийлүүлэхээр санал болгож буй барааны техникийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх</li> <li>-Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1 дэх заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдлийг ирүүлэх.</li> <li>-Тендерийн материалыг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх</li> <li>- Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаарх мэдэгдлийг ирүүлэх.</li> <li>-Баталгаат хугацаа олгох баримт бичиг /1 жил/ :</li> </ul>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулсан тендерийн барууллага бүхий багцуудаас бүрдэнэ: <del>ДАВРЫН МҮР, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: БАГЦГҮЙ.</del></p>

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
			Нийлүүл эх хамгийн эхний хугацаа	Нийлүү лэх эцсийн хугацаа	Нийлүүл эгчийн санал болгосон хугацаа
1	2	5	6	7	8
Био бордоо худалдан авах	- техникийн тодорхойлолтонд тавьсан шаардлагыг хангасан байх	Орхон аймгийн Жаргалан т сумын ЗДТГ	7 хоног	хүсэлт тавьсан аас хойш 30 хоног	Нийлүүл эгч санал болгоно.

**БАТЛЯВ:**  
**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН**  
**ГАЗРЫН ДАРГА** *Т.Энхжаргал*  
**БИО БОРДООНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

№	Нэр төрөл	Техникийн үзүүлэлт	ЖИДСИ ХИНЖСЛЭЛ	Тоо ширгэдэг
1	Био бордоо	Агрохимийн шинжилгээний дүн: фосфор 37%, азот 2,8%, Калци 0,3%-иас ихгүй, төмөр, бор кобальт, молибедин, зэс, цайр, мangan зэрэг ургамал ургалтанд шаардагдах микро эльментүүд агуулагдах, отөг бууц сайн задарсан байх, иэг шуудайнд 50кг-с доошгүй жинтэй байх	кг	19240

Боловсруулсан  
 ОНӨХМЭРГЭЖИЛТЭН *Э.Одсүрэн*

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Жаргалант сумын Засаг даргын Тамгын дарга Т.Энхжаргал**

танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэг ж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа КС	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[1]</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хугацаа</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хугацаа мөрдөнө.   |
| <b>9. Алданги</b>   | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн  |

<b>оногдуулах</b>	бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

### Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>	a. Барааг хүлээн авах комисс шалгаж актаар хүлээн авна.
<b>2. Барааны нийлүүлэл т ба баримт бичгийн бүрдүүлэл т (ГЕН – 2)</b>	a. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol>
	Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
<b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>	a. Баталгаат засварын тусгай шаардлага. /Компани санал болгоно. Баталгаат хугацаа 1 жилээс багагүй байх.
<b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>	a. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **[100]<sup>1</sup>**хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup> a. Алданги оногдуулах хувь: **[Хоногт гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь]**  
Алдангийн нийт дүн: **[Гэрээний үнийн дүнгийн 10 хувь]**

---

<sup>1</sup>Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дун гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч \_\_\_\_\_ нь  
\_\_\_\_\_ нэр төрлийн

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын  
\_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

